



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/121

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417 дүгээр тогтоол, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 27.5 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсан холбоотойгоор архивын баримтыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч С.Батдорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Нарийн бичгийн дарга Б.Батцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч)

Гишүүд Б.Энхбаяр (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Төрийн захиргаа, эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга)

Б.Амаржаргал (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан)

Б.Лхагвабаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн гэрээт архивч)

2. Тус газрын архивын баримтыг хууль, журамд заагдсаны дагуу данс, бүртгэл үйлдэж, хүлээлцэхийг ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

